

# ҮУЛ УУРХАЙ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНИЙ ЭРХ<sup>1</sup>



Монгол Улс газарзүйн байрилаараа өндөрлөг бүс нутагт хамаардаг тул уур амьсгалын өөрчлөлтөд дэлхийн дунджаас 3 дахин илүү өртөөг ба экосистем нь маш эмзэг. Нийт нутгийн 72 хувь цөлжилтванд өртсөн бөгөөд усны нөөц хурдацтайгаар хомсдож, 5128 голын 852, 9306 булаг шандны 2277, 3747 нуур цөөрмийн 1181, 429 рашааны 60 нь ширгээд байна. Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар маш хурдацтай хөгжик байгаа нь эдийн засгийн хувьд сайшаалтай хэдий ч ашигт малтмалын хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоо сул, хэрэгжилт хангалтгүй байгаагийн улмаас байгаль орчин, агаар, усны нөөц бохирдож, улмаар олон хүний үндсэн эрхүүд зөрчигдөхөд хүргэж байна. Уул уурхайн салбар

тулхэцтэй хөгжихийн хэрээр мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлалын салбар эзэмшиж буй газраасаа шахаждан, улмаар хот руу нүүх нүүдэл ихсэж байна. Монгол Улс нь Киотогийн протокол, хүний эрхийн гэрээ конвенци, Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн конвенци, Рамсарийн конвенци, Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенци, Биологийн төрөл зүйлийн тухай конвенциор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхгүй байна. Мянганы хөгжлийн зорилтын 7а-д 2015 он гэхэд газар нутгийнхаа 30 хувийг тусгай хамгаалалтад авна гэсэн үүргэг амлалтаасаа ухарч, тусгай хамгаалалттай газар нутгаас 62,256.58 гектар газрыг төсвийн хөрөнгөөр хайгуул хийх зорилгоор 2.9-6.3 жилийн хугацаагаар нөөцөд авчээ.

## Уул уурхайн замбараагүй үйл ажиллагаанаас үүдэн иргэдийн:

- Эрүүл аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах
- Уламжлалт соёл, ёс заншилаа хадгалах, амьжиргааны эх үүсвэрээ сонгох, хамгаалуулах
- Газар эзэмших, өмчлөх
- Ундны цэвэр усаар хангагдах
- Хөдөлмөрлөх, аж ахуй эрхлэх
- Шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхээ сэргээлэх зэрэг эрх нь түгээмэл зөрчигдөж байна.

## ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ҮРДАГАВАР<sup>1</sup>

Байгаль орчны хуулиуд хоорондоо зөрчилдөөнтэй, байгалийн нөөцийг ашиглах стандарт болон хуулийн хэрэгжилтийг хангаж буй эсэхийг тодорхойлох стандартыг тогтоогоогүй, хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй, маргаан шийдвэрлэх асуудлыг орхигдуулсан.

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь Газрын тухай болон Ашигт малтмалын тухай хуультай уялдаагүйгээс энэ үнэлгээг ашигт малтмал ашиглах зөвшөөрөл олгогдсоны дараа хийдэг тул шийдвэр гаргахад нөлөөлдөггүй.
- Усны нөөц хэрэгцээгээ хангаагүй байж олборлолт эхлүүлэх, байгаль орчинд халтайг нь шинжлэх ухаанаар тогтоосон газар уурхай байгуулах шийдвэр гаргаж байна.
- Байгаль орчны хохирлыг төр нэхэмжилнэ гэсэн заалт ашиг сонирхлын зөрчлийн улмаас хэрэгждэггүй.

## КЭЙС<sup>2</sup>

4 аймгийн 10 гаруй сумын 120 цэгт 53,5га талбайн 203,508мз хөрс цианит, мөнгөн усаар бохирдоод байна. 1992 оноос хойш улсын хэмжээнд 14,565 га газар уул уурхайн нөлөөллөөр эвдрэлд орсон ч 3,708 га-д зөвхөн техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Орд ашиглах явцад нуур орчмын байгаль орчин, хүн, амьтанд сөргөөр нөлөөлж, улмаар Байгаль нуурт бохирдол нь хүрнэ гэж эрдэмтэд дүгнэсээр байхад цэнгэг усны нөөцийн 74 хувийг агуулдаг Хөвсгөл нуурын орчмын фосфоритын ордыг ашиглах шийдвэр гаргасан. Оюутолгой, Тавантолгойн ордыг ашиглах үүднээс өмнө бүс рүү ус татах Орхон, Хэрлэн голуудын төслийг иргэдийн эсэргүүлийг үл харгалzan хэрэгжүүлэх гэж байна.

<sup>1</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг [www.upr-mongolia.mn](http://www.upr-mongolia.mn) вэб хуудаснаас үзнэ үү.

<sup>2</sup> Төрийн Бус Байгууллагудын Хүний Эрхийн Зөвлөлд илгээсэн мэдээлэлд тулгуурлан бэлтгэсэн тул нэмж тоо баримт, жишээ, тохиолдол оруулах боломжгүй байсан болно.

- Химиин хорт бодисын хадгалалт, зөөвөрлөлт, хэрэглээнд тавих хяналт сул.
- Олборлолт хийсэн газраа нөхөн сэргээдэггүй, байгаль орчинд халтай, хоцрогдсон олборлох технологи хэрэглэдэг, уурхай тус бүр дураараа зам гаргаж хүнд даацын машинаар, стандартын хучлагагүйээр тээвэрлэдэг зэрэг зөрчил нь байгаль орчин, усны нөөц, ай сав, түүний ойр орчмыг бохирдуулах, устгах аюулыг дагуулж байна. Энэ нь Монголоор тогтохгүй бүс нутгийн байгаль орчин, биологийн төрөл зүйлд сөрөг нөлөөллийг үзүүлж байна.

Заншлын хуулийн дагуу эзэмшиж байгаа малчдын бэлчээр, өвөлжөө, хадлангийн газрын эрхийг баталгаажуулах, зөрчигдсөн тохиолдолд эрхийг нь сэргээх механизм байхгүй.

- Газраа алдсан, шахагдан гарсан иргэд мал малгааны дэд бүтэцгүй, өвлүүлэх хөрөнгөгүй, нүүдлийн соёлоо хойч үедээ өвлүүлэх боломжгүй болж, амьжиргааны эх үүсвэрээсээ салж дотоодын дүрвэгсэд болж байна.

Ашигт малтмалын лиценз олголт олон улсын гэрээ конвенци болон дотоодын хуулийг зөрчиж, хяналтгүй явагддаг.

- Газрын тухай хуульд газар ашиглалтыг бүх шатны газар зохион байгуулалтын төвлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ гэж хуульчилсан ч Ашигт малтмалын хуульд энэ заалт ороогүй тул тусгай зөвшөөрөл олгоходоо энэ төвлөвлөгөөг харгалzan үздэггүй.
- Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, амьжиргааны эх үүсвэрээ хамгаалаулах, эрүүл мэндээ хамгаалаулах эрх зөрчигдөхөд хүрч байна.

Аливаа шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх механизм байхгүй, ТББ-д нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргах эрх олгогдоогүй.

- Иргэдийг газар нутгаас нь шахан гаргах, хүчээр нүүлгэх, хөөн зайтуулах зэрэгээр эрхийг нь зөрчсөөр байхад тэд энэ талаар шийдвэр гаргах үйл явцад оролцож чадахгүй байна.

Уул уурхайн салбар тулхэцтэй хөгжиж байгаатай холбоотой шинээр үүсэн гарч буй асуудал:

- Уул уурхайд хөдөлмөр эрхлэхтэй холбоотойгоор зарим сум суурин газрын хүн амьн механик ёсөлт нэмэгдэж байхад эрүүл мэнд, боловсрол болон төрийн бусад үйлчилгээний төсөв бүртгэгдсэн хүний тоогоор батлагдаж, үүний улмаас давхар зөрчлийг дагуулж байна.
- 100,000 гаруй “нинжа” буюу гар аргаар алт олборлогчдын эгнээг малгүй болсон иргэд, хот, хөдөөгийн ядуу хүн ам улам бүр тэлж байна. Мөн хайгуул, олборлолтын лицензийн улмаас газраа алдсан иргэд ч үүнд хамаарна.
- Уул уурхайн компанийн газар, усны төлбөрөөс төсвөө бие даан бүрдүүлдэг сумд санхүүгийн хувьд бүхэлдээ алтны компаниас хараат болсон.

Цөлөрхөг бүсийн сонгомол говь нутгийн нэн эмзэг хөрсөн дээгүүр Таван Толгойн нүүрсийг 80-100тн хүнд даацын машин 240 км урт, 32 салаа замаар стандартын хучлагагүйгээр ил задгай тээвэрлэж байгаагаас хөрс, ургамлын бүрхүүл гэмтэж, тоосжилтын хэмжээ хүн, мал, амьтдан амьдрах боломжгүй түвшинд хүрснээр нүүрсний замын дагуу амьдарч байгаа иргэд шахагдан гарч “дүрвэгсэд” бий болж байна.

Алт олборлох болсон сүүлийн 15 жилд гол усыг хаан, урсгалыг өөрчлөх, ус бохирдуулах үйл ажиллагаа Байгаль нуурыг тэтгэдэг усны сав газрын 50 хувийг хамраад байна.

Монгол Улс 300 гаруй сумтайгаас 90 орчим хувьд уул уурхайн лиценз олгогдсон, тал орчмынх нь газар нутгийн 50 гаруй хувьд лицензийн талбай олгогджээ. Тухайлбал, Заамар, Хонгор, Ханбогд, Цогтцэций сумын газар нутгийн 90 хувь лицензийн талбайд хамрагдсан.

Дархан цаазтай, тусгай хамгаалалттай, түх соёлын, байгалийн үзэсгэлэнт газар, хүн ам төвлөрсөн суурин газруудад лиценз олгодог. Тухайлбал, хүн амын 50 хувь амьдардаг Улаанбаатараас 70 км зайд орших Жанчивланд ураны хайгуул, Заамар, Цогтцэций, Цэнхэрмандал, Ханбогд, Хонгор, Мөрөн зэрэг хүн ам төвлөрсөн сууринд алт, зэс, нүүрс, фосфоритийн орд ашиглах лиценз олгогдсон.

Цогтцэций сумын иргэдийн эсэргүүцлийг үл харгалzan сумын төв, бэлчээр, хадлан тариалан бүхий газрын зориулалтыг өөрчлөн хайгуул, олборлолт эрхлэх лиценз олгосон.

Цогтцэций суманд 2,800 иргэн бүртгэлтэй ч одоо оршин сууж байгаа нь 5,800 болсон. Гэвч 2,600 хүнээр батлагдсан төсвийн хүрээнд иргэд төрийн үйлчилгээ авч байгаа бөгөөд энэ нь үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдын ачааллыг ихэсгэж, улмаар тэдний эрх ч мөн давхар зөрчигдөхөд хүрч байна.

“Нинжа” нар уламжлалт амьдралын хэв маягаасаа хагацаж, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр, боопчил, садар самуун, хүчирхийлэл цээглэсэн орчинд хөдөлмөрлөх, сурч боловсрох, амьд явах, өмчтэй байх зэрэг олон эрх нь зөрчигдөн амьдарч байна.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Иргэдийн төлөвлөгчдийн хурал 2009 онд 20,000 ам.доллар авч орон нутгийн тусгай хэрэгцээний газар чөлөөлж, уурхайд олгосон нь шалгагдаж байгаа.

## МОНГОЛЫН ТӨРИЙН БҮС БАЙГУУЛЛАГУУД ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА

- Байгаль орчны аливаа асуудлаар шийдвэр гаргахдаа мэдээлэл авах, оролцох болон шүүхэд хандах тухай” НҮБ-ын Аархусын конвенцид нэгдэн орох;
- “Уугул иргэдийн эрхийн тухай” НҮБ-ын тунхаглалд үндэсний хууль тогтоомжуудыг нийцүүлэх, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 169-р конвенцийг батлах, хэрэгжүүлэх;
- Ашигт малтмалын хуулийн 57.2 заалтыг хүчингүй болгож техник эдийн засгийн үндэслэл, лиценз ба гэрээг нээлттэй байлгаж, хэрэгжилтэд төрийн болон олон нийтийн хяналт тавих механизмыг бүрдүүлэх;
- Гар аргаар олборлох салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, эрхийг нь хамгаалах;
- Хүний эрхийг бодитой хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэх механизмуудыг үндэсний хуулиудад тусгах, хэрэгжүүлэх;
- Тусгай хэрэгцээний газрын томъёоллыг шинэчлэн найруулж, олон талт хэлэлцэрээр хамгаалалтад авсан газар, байгалийн үзэсгэлэнт шүтээн газруудыг багтаах;
- Засгийн Газрын 86-р тогтоолоор хайгуул хийхээр нөөцд авсан газрыг буцаан тусгай хамгаалалтад авах, тусгай хамгаалалттай газрыг нэмэгдүүлэх амлалтаа биелүүлэх бодитой арга хэмжээ авах, үр дүнгээ НҮБ-д тайлагнах;
- Хүн ам төвлөрсөн суурин газрын орчимд олгогдсон лицензүүдийг дахин хянах, олон улсын стандартын дагуу үнэлгээ хийж, аудитлан, нийтээр хэлэлцүүлсний үндсэн дээр сэргээх;
- Олон улсын ач холбогдол бүхий Хөвсгөл нуур, бусад усны нөөц газрыг хянан үзэж, Олон улсын хамгаалалттай экологийн бүс нутагт хамруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Уул уурхай, сэргээгдэх эрчим хүч, нөхөн сэргээлтийн технологи хөгжүүлэх, техникийн ба санхүүгийн туслалцаа авах талаар олон улсын холбогдох сангруудад хандах;
- Стратегийн орд газрыг ашиглах компаниудад усны нөөц ба хэрэглээгээ тайлагнахыг шаардах;
- Уул уурхайн үйлдвэрлэлийн нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын стандартын дагуу хийлгэн, тэдгээрийн аудитлагдсан тайлан төлөвлөгөөг хөрөнгө оруулалтын нөхцөл болгох, сөрөг нөлөөллөөс сэргийлэх төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх болон
- Уул уурхайн үйлдвэрлэлийн ISO 14 000, компанийн нийгмийн хариуцлагын стандартад нийцүүлэн үнэлгээ хийх, хянах механизмыг бүрдүүлж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХ<sup>1</sup>



Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци, түүний нэмэлт протоколд нэгдэн орсон, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангаж, хамгаалах чиглэлээр хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр баталсан хэдий ч хууль хэрэгжүүлэх механизмыг хангалтгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх бүхий этгээд биши, тусламж,

халамж хүртэгч гэх хандлага хууль тогтоомжид давамгайлсан, барилга байгууламж, хотын гудамж талбай, олон нийтийн үйлчилгээ, сургууль соёл, мэдээлэл авах зэрэг зөвлөн болон хатуу дэд бүтэц хүртээмжгүй байгаа зэрэгээс үүдэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах боломжгүй болж, бусдаас хараат байдлаар амьдарч байна.

## Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд:

- Бие даан, хараат бус амьдрах
- Хөдөлмөрлөх
- Нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох
- Сурч боловсрох, мэдээлэл хүлээн авах
- Чөлөөтэй зорчих
- Эрүүл аюулгүй орчинд амьдрах
- Эрүүл мэндээ хамгаалуулах эрхүүд түгээмэл зөрчигдэж байна.

## ТҮЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ҮР ДАГАВАР

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенциид заасан "Хүртээмж" хэмээх ойлголт Монгол Улсын хууль тогтоомжид бүрэн агуулгаараа тусгагдаагүй. Тиймээс:

- Зарим нэг стандарт батлагдсан ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрэгцээтэй бүх үйлчилгээний талаар нэгдсэн заавар стандарт байхгүй.
- Хот дотор таксинаас бусад нийтийн тээврийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үнэ төлбөргүй зорчих эрхтэй ч энэ нь хэрэгждэггүй.
- Хот хооронд зорчих талаар зохицуулсан хууль тогтоомж байхгүй.
- Мэдээллийн хүртээмжийн талаар төр засагт ямар ч ойлголт байхгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилт сул. Тиймээс:

- хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурх орчин бүрдүүлээгүй
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш бэлтгэгдээгүй, багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт энэ асуудал тусгагдаагүй
- сурх бичиг хүртээмжгүй, сонголтгүй
- тусгай сургуульд сургах ёстой гэх хандлага түгээмэл
- их дээд сургуулийн орчин бүхэлдээ хүртээмжгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хуулийг хэрэгжүүлэх арга зам тодорхой бус, хариуцлагын тогтолцоо сүл. Тиймээс:

- Ажиллах орчин бүрдээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулж байгаа ажил олгогчид үзүүлэх дэмжлэг нь хүнд суртал ихтэй, тиймээс тэд гэр бүлийн хүрээнд хөдөлмөрийн мөлжлөгөд өртөх эрсдэл өндөртэй.

## КЭЙС<sup>2</sup>

Тэргэнцэртэй хүн зорчих налуу зам цөөхөн, хэдэн байгууллагын гадна байгааг эс тооцвол нийтийн үйлчилгээний газруудад зориулалтын зам байхгүй байна.

Жижиг оврын хувийн автобус хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчилдэггүй. Тэргэнцэртэй хүмүүс нийтийн тээврээр зорчих нөхцөл бүрдээгүй. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хөдөөгийн хүмүүс гэрээсээ гарч чадахгүй нөхцөлд амьдарч байна.

Дохионы хэлний нэг ном, Монголын үндэсний олон нийтийн телевизийн мэдээ дохионы орчуулгатай явдгийг эс тооцвол өөр зүйл алга.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 50 гаруй хувь нь ерөнхий боловсролын сургуульд элсэн ордог ч суурь боловсрол эзэмшиж байгаа нь 14 хувь болтлоо буурсан. Нийслэлд тэргэнцэртэй хүүхэд орох боломжтой хоёрхон сургууль байна. Хөгжлийн бэрхшээл, наснаас үл хамааруулан тусгай анги нээж бөөгнүүлэн сургалт явуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн талаар дэлгэрэнгүй судалгаа байхгүй. 2004 онд явуулсан түүвэр судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 26,4 хувь л хөдөлмөр эрхэлж байна.

<sup>1</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг [www.upr-mongolia.mn](http://www.upr-mongolia.mn) вэб хуудаснаас үзнэ үү.

<sup>2</sup> Төрийн Бус Байгууллагудын Хүний Эрхийн Зөвлөлд илгээсэн мэдээлэлд тулгуурлан бэлтгэсэн тул нэмж тоо баримт, жишээ, тохиолдол оруулах боломжгүй байсан болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувиараа хөдөлмөр эрхлэх болон аж ахуй эрхлэлтийг дэмжих буй төрийн бодлого хангалтгүй.

- Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд цөөн төрлийн гар урлалын зүйлс хийх сургалтад л хамруулдаг. Энэ нь тэднийг үр бүтээл муутай хөдөлмөр эрхлэхэд түлхэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ маш доогуур байна.

- Авч байгаа тэтгэвэр, тэтгэмжээрээ өөрийгөө хангах боломжгүй тул бусдыг царайчлан амьдрахад хүрдэг.
- Гэр бүл, асран хамгаалагчдын зүгээс ялгаварлах, тээршаах тохиолдол гардаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх статистик мэдээ, тоо баримт зөрүүтэй.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хэрэгжүүлэх талаар төрийн бодлого, шийдвэр оновчтой бус гарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг зөвхөн Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яамны ажил гэх өрөөсгөл хандлага байдаг.

- Салбар хоорондын хамтын ажиллагаа байхгүй.
- Хууль тогтоомжийн уялдаа холбоо муу байгаагаас хэрэгжилтэд нь сергөөр нөлөөлдөг.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн хalamжийн үйлчилгээ үзүүлэх заалт хэрэгждэггүй.

- Асран хамгаалагчаас хараат болж, ялгаварлагдах, гадуурхагддаг.
- Гэр бүлийнхний зүгээс хүчирхийлэлд өртөх болон амь насaa алдаад ч хүрдэг.

Олон нийт, төрийн албан хаагчдын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн хalamж хүртэгч, идэвхигүй бүлэг хэмээн үзэх хандлага түгээмэл.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох, эрхээ эдлэх боломжийг хязгаарлаж, ОУ-ын гэрээ, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлдөг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй гэр бүл ч давхар ялгаварлалд өртдөг.

Банк, санхүүгийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөгжлийн бэрхшээлтэйгээс нь шалтгаалан зээл өгөхөөс татгалздаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хийсэн бүтээгдэхүүн нь зах зээлд өрсөлдөх чадвар муу, хөдөлмөр зарцуулалт их, ашиг муутай байдаг.

Амьжиргааны доод түвшин 60,48 ам.доллар байхад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дунджаар 47 ам.доллартай тэнцэх тэтгэвэр, 29 ам.доллартай тэнцэх тэтгэмж авч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн орлого нийт өрхийн дундаж орлогос 2,5-3 дахин бага. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн асарч буй хүнд сард 17,5 ам.доллартай тэнцэх тэтгэмж өгч байна.

Албан статистикт 79,000 хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байгаа гэж гарсан бол албан бус статистикаар 121,000 гэсэн тоо байдаг. Албан статистикт 6,897 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгааг дурьдсан бол БСШУЯ-ны мэдээнд 35,899 гэжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих Үндэсний хороо байдаг хэдий ч орон тооны ажилтан байхгүй, цуглаж хурал хийлгүй жил болох ч тохиолдол гардаг.

2009 онд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөдөө аваачиж хаясныг олж аварсан бол өөр нэг хүүхдийг эцэг нь өвөл хөлдөөж алсан нь тогтоогдсон.

Судалгаанд хамрагдсан сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 46,6 хувь нь бусад хүүхдүүд шооплж дээрэлхэдэгээс хүндрэл учирдаг гэж хариулжээ.

## МОНГОЛЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх ажилд хүний эрхийн үүднээс хандаж, олон улсын байгууллагын зөвлөмж, бусад орны туршлагыг нэвтрүүлэн ажиллах, тэдний асуудлыг зохицуулан шийдвэрлэх тогтмол ажиллагаатай бүтэц бий болгох;
- Нийтийн тээврийн үйлчилгээ, барилга байгууламж, гудамж талбай мөн мэдээллийг хүртээмжтэй болгох үүднээс орчин үеийн ололт амжилт, гадаад орны туршлагаас суралцан цогц арга хэмжээ авах;
- Сургагч багш нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй харилцах, ажиллах ур чадвартай болгох үүднээс мэргэжил, аргазүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж, сургагч багш нарыг чадавхижуулах арга хэмжээ авах, брайль үсгийн ном, ярьдаг ном, дохионы хэлний талаар хуульчилж, стандартчилах, хэрэглэх талаар заавар, дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих механизмыг боловсронгуй болгох, хөдөлмөрийн мөлжлөгөөс сэргийлэх үүднээс асран хамгаалагч, тэдний хоорондын харьцаа, тэтгэвэр тэтгэмж, хөдөлмөр эрхлэлтийг нарийн зохицуулсан эрх зүйн орчин бүрдүүлэх;
- Тэтгэмжийн хэмжээг бэрхшээлээс хамааран ялгавартай тогтоох, түүний дагуу арга хэмжээ авах, зохистой орон байраар хангах ажлыг орон сууцжуулах хөтөлбөрт тусгах, бие даан амьдрахад дэмжлэг үзүүлдэг байгууллага бий болгох, төрөөс санхүүжүүлэх болон
- Эмнэлгийн үйлчилгээ, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хүртээмжтэй болгох, тогтмол хэрэглэдэг эм тариаг төрөөс даах нь зүйтэй.

# СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ<sup>1</sup>

Хүний эрхийн олон улсын гэрээнүүдэд заасан сонгох, сонгогдох эрхийн талаарх ихэнх зарчим, стандартууд Монгол Улсын Үндсэн хууль, сонгуулийн хууль тогтоомжуудад тусгагдсан хэдий ч хэрэгжилт нь хангалтгүй байгаагийн улмаас олон нийт сонгуулийн явцыг шүүмжлэх, үр дүнг эсэргүүцэн жагсаж, цуглах, сонгуульд оролцож идэвхи

суларч сонгууль ирцдээ хүрэхгүй дахин явагдах зэрэг сөрөг үр дагавар нийгэмд гарч байна. Тухайлбал, Монгол Улсад 2008 оны 7 сарын 1-нд анх удаа онц байдал зарласан бөгөөд энэ нь Улсын Их Хурал (УИХ) -ын сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн олон нийтийн жагсаал цуглаанаас үүдэлтэй байсан юм.

## ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ҮР ДАГАВАР

Үндсэн хууль болон сонгуулийн хууль тогтоомжуудад сонгуулийн тэгш эрхийн зарчим тусгагдаагүй.

- Адил тооны санал өгөх буюу саналын жин тэгш байх, нэг тойрог дахь сонгогчдын тоо тэгш байх зарчим хэрэгжихгүй байна.
- Нэр дэвшигчдийн өрсөлдөх нөхцөл боломж тэгш бус.

## КЭЙС<sup>2</sup>

Сонгогч аль тойротг харьялагдахаас хамааран 2-4 санал өгч байна. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүдийн сонгогчийн тоо харилцан адилгүй. Нэг нь 13'398 сонгогчтой байхад нөгөө нь 39'617 сонгогчийг төлөөлж байна. Сурталчилгааны үргэлжлэх хугацаа өөр, эрх барьж буй намын нэр дэвшигчид төрийн эх үүсвэрийг сурталчилгааны ажилд зарцуулдаг. Мөн бие даан нэр дэвшигчдэд намын нэр дэвшигчээс илүү өндөр шалгуур тавьдаг. 2008 оны УИХ-ын сонгуулиар жижиг намын гурван нэр дэвшигчийг сонгуулийн дүн эцэслэн гараагүй байхад тойргийн хорооны зөвшөөрөлгүйгээр баривчлан, хорьсон.

Сонгуулийн бүх нийтийн байх зарчмыг хэрэгжүүлэхэд сонгогчдын нэрийн жагсаалтад сонгуулийн насны бүх хүмүүсийг бүртгэх явдал нэн чухал ч энэ ажил зүй зохистой хийгдэхгүй байна.

- Сонгогчдыг нэрийн жагсаалтад хууль бус шалтгаанаар бүртгэхгүй байх, давхардуулан бүртгэх, тоог ихэсгэх, барагах явдал гардаг бөгөөд үүний улмаас иргэдийн сонгох, сонгогдох эрх зөрчигдэж, зарим сонгогчид сонгуульд оролцож чаддаггүй.
- Нэрийн жагсаалтыг хуульд заасан хугацаанд ил тавьдаггүй тул хөндлөнгийн хяналт тавих боломж хязгарагддаг.

Сонгуулийн явцад тухайлбал, санал хураах болон тоолох явцад шударга, алдаа мадаггүй байх сонгуулийн зарчим хэрэгжихгүй байна.

- Хэсгийн хорооны бүрэлдэхүүн жижиг нам болон бие даан нэр дэвшигчдийн төлөөлгүйгээр, хоёр гол намын төлөөллөөс бүрддэг нь сонгуулийн үйл ажиллагаанд хардлага эргэлзээ төрүүлэхэд хүргэж байна.
- Сонгуулийн ерөнхий хороо 2008 оны УИХ-ын сонгуулийн санал хураах, тоолох үйл явц удааширч болзошгүй болохыг урьдчилан мэдэж байсан.

Сонгогчдын нэрийн жагсаалт гаргах эрх бүхий гурван байгууллага хол зөрүүтэй өөр өөр тоо гаргадаг бөгөөд зөрүү нь нийт сонгогчдын 20-24 хувьтай тэнцэж байна.

- 4 хүрэхгүй сарын зөрүүтэй явагдсан 2008 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт 237/272 сонгогчоор зөрсөн бөгөөд энэ нь нийт сонгогчдын 14-18 хувьтай тэнцэнэ.
- 2009 оны 10 дугаар сард болсон УИХ-ын нөхөн сонгуулийн тойрог дахь сонгогчдын нэрийн жагсаалтад 98'747 сонгогч бүртгэгдсэн байсныг хэсгийн хороо нягтлан шалгах нэрээр 27'043 сонгогчийг нэрийн жагсаалтаас хассан байсан.

Сонгуулийн нэг хэсэгт 2000-6000 сонгогч байхад хэсгийн хороонд 13-15 хүн ажилладаг. Хэсгийн хорооны ажлын ачааллаас болж урт дараалал үүсэн, сонгогчид саналаа өгч чадахгүй үлдэх тохиолдол ч гардаг.

- 2008 оны УИХ-ын санал хураах ажил 15 цаг, санал тоолох ажил дунджаар 72 цаг үргэлжилсэн бөгөөд нийт 87 цагийн туршид сонгуулийн хэсгийн хорооны гишүүд тасралтгүй ажиллахад хүрсэн. Бараг бүтэн 4 өдөр, шөнө тасралтгүй ажилласан хүмүүсийн хөдөлмөрийн бүтээмж, үйл ажиллагаа эргэлзээгүй, алдаа мадаггүй байх боломжгүй юм.

<sup>1</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг [www.upr-mongolia.mn](http://www.upr-mongolia.mn) вэб хуудаснаас үзнэ үү.

<sup>2</sup> Төрийн Бус Байгууллагуудын Хүний Эрхийн Зөвлөлд илгээсэн мэдээлэлд тулгуурлан бэлтгэсэн тул нэмж тоо баримт, жишээ, тохиолдол оруулах боломжгүй байсан болно.



Эрх зөрчигдсөн тохиолдолд эрхээ сэргээлгэх механизм тодорхойгүй, сонгуулийг зохион байгуулах байгууллагын үйл ажиллагаа нь шүүхийн хяналтаас гадуур байна.

- Сонгуулийн хороодод “дур зоргоор аашлах” боломжийг олгож, иргэд сонгох, сонгогдох эрх нь зөрчигдсөн тохиолдолд эрхээ сэргээлгэх боломжгүй болсон.

Сонгуулийн үйл явцад сонгогчдыг төлөөлөн хяналт тавих эрх зүйн зохицуулалт байхгүй.

- ТББ-үүд сонгогчдыг төлөөлөн хяналт тавих санаачлага гаргаж байгаа ч хөндлөнгийн мониторинг хийх боломж нь хязгаарлагддаг.

УИХ-ын сонгуулийн хуульд байсан квотыг (улс төрийн намаас нэр дэвшигчдийн 30 хувь эмэгтэй) 2008 оны сонгуулийн өмнө хүчингүй болгосон.

- Эмэгтэйчүүдийн хууль тогтоох байгууллагад сонгогдох эрх хязгаарлагдаж байна.

УИХ-ын сонгуулийн хуулиар санал авах өдөр эх орондоо байгаа сонгогчид зөвхөн саналаа өгөх эрхтэй.

- Гадаадад байгаа Монгол Улсын иргэдийн сонгох эрх зөрчигддэх байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрх зөрчигддэх байна.

- Хөгжлийн бэрхшээлээсээ хамааран саналаа чөлөөтэй өгөх, бодит тэнцвэртэй мэдээлэл авах боломж нь хязгаарлагддаг.
- Санал авах байр, түүний орчин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй биш.

Сонгуулийн ерөнхий хороо сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил хийдэггүй.

- Иргэдийн сонгох, сонгогдох эрх, сонгуулийн зарчмын талаарх мэдлэг боловсрол суулт байна.

Сонгох, сонгогдох эрх зөрчигдсөн тохиолдолд эрхээ сэргээн тогтоолгох нэхэмжлэл гаргахад шүүх хүлээж авахгүй байх нь түгээмэл. Сонгуулийн маргааныг шүүхээс өмнө сонгуулийн хороод шатандaa шийдвэрлэх шаардлагатай ч өргөдөл, гомдлыг хүлээн авдаггүй, авсан ч хянан шийдвэрлэдэггүй, Үүнийхээ төлөө ямар ч хариуцлага хүлээдэггүй.

Сонгуулийн үйл явц санал хураахас бусад бүх тохиолдолд ил тод байна гэсэн хэдий ч иргэний нийгэм, хөндлөнгийн байгууллагын хяналт, оролцоогүй, хаалттай явж ирсэн.

Хүн амын 51 хувийг эзэлдэг эмэгтэйчүүд Парламентад дөнгөж 3,9 хувийн төлөөлөлтэй байна.

Нийт сонгогчдын 18 хувьтай тэнцэх буюу 250,000 сонгогч сонгох эрхээ эдэлж чадахгүй байна.

Сонгуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 85 хувь нь сонгуульд огт саналаа өгч байгаагүй.

Иргэдийн сонгуульд оролцох идэвхи оролцоо буурч байна. Сонгуулийн эцсийн үр дүн мөнгөөр шийдэгдэх, сонгогчдод эд бараа, мөнгө амлах тараах зэрэг зөрчил түгээмэл гарах болсон.

## МОНГОЛЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА

- Тэгш эрхийн зарчмыг Үндсэн хууль болон сонгуулийн хууль тогтоомжид тусгах, иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийн үйл явцад хяналт тавих, ажиглалт хийх эрх зүйн орчинг бүрдүүлэх, энэ ажилд иргэний нийгмийн байгууллага, сонгогчдыг өргөнөөр оролцуулах;
- Санал авах байрны стандартыг сонгогчийн саналаа нууцаар, чөлөөтэй өгөх зарчимд нийцүүлэн шинэчилж мөрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцгой хэрэгцээг тусгах;
- Шударга, үнэн сонгууль явуулахад сонгуулийн хэсгийн хороодын бүрэлдэхүүн, ажиллах орчин нөхцөл, ажлын зохистой цаг чухал гэдгийг хүлээн зөвшөөрч, энэ чиглэлээр дорвitoй өөрчлөлт хийх;
- Гадаадад байгаа иргэдийн сонгох эрхийг эдлүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Улс төрийн нам, эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна гэсэн хүчингүй болсон хуулийн заалтыг сэргээх болон
- Сонгуулийн маргаан, түүний харьялал, хянан шийдвэрлэх журмыг хуулиар нарийн тодорхойлж, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг бодитой болгох нь зүйтэй.

# ХҮНСНИЙ ТУСГААР ТОГТНОЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ<sup>1</sup>



Монгол Улс хэдийгээр өргөн уудам нутаг, олон толгой малтай боловч ядуурлын улмаас иргэдийн хүнсний эрх зөрчигдөж, 5 хүртэлх наасны 4 хүүхэд тутмын нэг нь өсөлт хоцорсон, 8 хүүхэд тутмын нэг нь тураалтай, 32,1 хувь нь сульдаатай,

43,2 хувь нь Д амин дэмийн дутагдалд орсон байна. Түүнчлэн жирэмсэн эхчүүдийн 37,1 хувь, амаржсан эхчүүдийн 30,5 хувь нь Д амин дэмийн дутагдалтай байна. Улсын хэмжээнд нийт өрхийн 57,9 хувь нь илчлэг дутуу хооллож байна.

## Монгол Улсын хүн амын хувьд:

- Зохистой хоол хүнсээр хангагдах
- Аюулгүй хүнсээр хангагдах
- Хүнсээр хүртээмжтэй хангагдах
- Хүнс худалдан авах чадавхитай байх өлсгөлөнгөөс ангид байх
- Соёл уламжлалдаа нийцсэн хүнсээ хэрэглэх эрхүүд түгээмэл зөрчигдөж байна.

## ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ҮР ДАГАВАР

- Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэггүй.
- Эдийн засаг нийгэм соёлын эрхийн пактын хэрэгжилтийн тайланг цаг хугацаанд нь явуулдаггүй.
  - НҮБ-аас хүнсний эрхтэй холбогдолтой гаргасан зөвлөмж, асуулгын дагуу хангалттай арга хэмжээ авдаггүй.

1999 онд "Хүнсний тухай хууль"-ийг шинэчлэн найруулахдаа хүнсний эрхтэй холбоотой олон чухал бодлого, чиг үүрэг, зохицуулалтыг хассан. Хүнсний эрхийг цогцоор хангах, хэрэгжүүлэх, хамгаалах, нөхөн төлбөр олгох, хохирлыг барагдуулах, төлөөлөн нэхэмжлэх эрх зүйн орчин өнөөдрийг хүртэл бүрдээгүй.

- Одоо мөрдөгдөж байгаа хуулиуд нь зөвхөн хүнсээр хангах, хүнсний аюулгүй байдлыг хангахад л чиглэдэг.
- Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт хүнсний эрхийн асуудал огт тусгагдаагүй.
- Хүн амыг шим тэжээлтэй, аюулгүй, уламжлалт ёс заншилд нь нийцсэн хүнсээр хүртээмжтэй, баталгаатай, боломжийн өртөгөөр хангах тогтолцоо бүрдээгүй хэвээр, эдгээр эрхүүд нь зөрчигдсөөр байна.

## КЭЙС<sup>2</sup>

2004 онд НҮБ-ын Хүнсний эрхийн тусгай илтгэгч Монгол Улсыг хүнсний хараат орон болсон гэж дүгнэлт гаргасан боловч Засгийн Газраас үүний дагуу авсан арга хэмжээ байхгүй байна. Импортын хүнс жилээс жилд нэмэгдсээр дотоодын хүнсний бүтээгдэхүүний 80 гаруй хувийг эзэлж байна.

- Нийт өрхийн 60 хувь хоногийн хоолны илчлэг нь дутагдалтай, өлмөн зэлмүүн амьдарч байна.
- Эмзэг бүлгийн иргэд өдөрт цөөн хооллож, 2-3 нэр төрлийн чанар муутай хүнсийг удаан хугацаагаар хэрэглэж байна.
- Хүнсний хангамж хүртээмжтэй ч иргэд худалдан авах чадвар муутайгаас хэрэгцээт хүнсээ авч чаддаггүй. Хоногийн илчлэгээ авахын тулд 1 хүн өдөрт 4,2 ам.доллар, сард 126 ам.доллар зарцуулах шаардлагатай бөгөөд үүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 60,8 ам.доллар (татвар, хураамжийт хасч, гаргт олгох дүн) хаана нь ч хүрэхгүй байна.

<sup>1</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг [www.upr-mongolia.mn](http://www.upr-mongolia.mn) вэб хуудаснаас үзнэ үү.

<sup>2</sup> Төрийн Бус Байгууллагудын Хүний Эрхийн Зөвлөлд илгээсэн мэдээлэлд тулгуурлан бэлтгэсэн тул нэмж тоо баримт, жишээ, тохиолдол оруулах боломжгүй байсан болно.

Хүнсний бүтээгдэхүүний хяналт шалгалт сул, хүн хүч, техникийн хүчин чадал хангалтгүй, чадавхи дутмаг. Мөн авилга, төрийн албан хаагчийн ёс зүйгүй байдал ч үүнд нөлөөлж байна.

- Аюулгүй хүнсээр хангагдах эрх зөрчигдөх эрсдэл өндөр байна.
- Хоол боловсруулах системийн өвчлөл нэмэгдэж, нас баралтын тодорхой шалтгаан болж байна.
- Малаас хүнд халдвартлагдаг бурцеллээз, сурьеэ, ям, лейкоз зэрэг өвчнийг оношлох, хянах чадавхгүй болсон.

Хүнсний асуудлаар хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангалтгүй.

- Хүн амын хүнсний эрхийн хэрэгжилтэд сайнаар нөлөөлж чадахгүй байна.

Үндэсний үйлдвэрлэл, өрхийн аж ахуйг дэмжих төрийн бодлого хангалтгүй, төрөөс зээл, татварын орчноор дэмждэггүй, борлуулалтын шударга, боловсронгуй тогтолцоо байхгүй.

- Монгол хүн байгаль, цаг уурын онцлогт тохирсон, уламжлалт хүнсээ хэрэглэх эрх зөрчигдэх байна.
- Малчид, тариаланчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлж, амьжираагаа дээшлүүлэх боломжгүй.

Газар эзэмших, ашиглах үйл явц хяналтгүй явагдсан, уул уурхайн үйлдвэрлэлд тавьдаг хяналт байхгүй.

- Томоохон аж ахуйн нэгжүүд их хэмжээний газар эзэмшиж, түүнийгээ өрхийн аж ахуй эрхлэгчдэд түрээслүүлснээр тэдний ашиг орлогыг бууруулсан.
- Уул уурхай, газар тариаланд усыг хямд нийлүүлж байгаа нь гамгүй хэрэглээг бий болгож, усны эх үүсвэр хомсдсон.

Олон улсын зээл, тусламжийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийх, иргэдийн оролцоог хангах, олон нийтэд ил тод мэдээлэл өгөх, эрх гэрийн хүнсний хараат бус байдлыг дэмжих үр дүнтэй бодлого, хөтөлбөр байхгүй.

- Зээл тусламжийн хэмжээ өндөр байгаа ч эмзэг бүлэг хүнсний хомсдолд улам бүр өртөж, үндэсний үйлдвэрүүд сэргэж чадахгүй байна.

Хүнсний эрхийг хангах, хамгаалах, нөхөн төлбөр олгох тогтолцоог бий болгоход Хүний эрхийн үндэсний комисс анхаарч ажилладаггүй.

Улсын мэргэжлийн хяналтын газрын хийсэн шинжилгээгээр хүнсний бүтээгдэхүүний дээжний 17 хувь, түүний түүхий эдийн дээжний 39 хувь бохирдолтой гарсан. Нян судалын шинжилгээнд хамрагдсан дээжийн 9,6 хувь нянгийн бохирдолтой, химийн шинжилгээгээр 4 хувь нь хортой, 10 хувь нь хүнд металлын бохирдолтой гарсан. Импортоор орж ирж буй хүнсний бүтээгдэхүүний дөнгөж 40 гаруй хувьд л шинжилгээ хийдэг.

"Сүү", "Иод дутлын эмгэгтэй тэмцэх", "Экологийн цэвэр бүтээгдэхүүн" зэрэг хүнсний бүтээгдэхүүний чиглэлээр 10 гаруй хөтөлбөр хэрэгждэг.

Дотоодын үйлдвэр, аж ахуй, цех болон өрхийн аж ахуй нь импортын хямд бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадавхигүй, бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна. Малчид, тариаланчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд өөрсдөө шууд нийлүүлэх бололцоогүй, ченжүүдээр дамжин борлуулалт хийгдэг тул үйлдвэрлэгчид болон хэрэглэгчид хохирч байна.

Үндны ус, малын бэлчээргүй болсон малчид уламжлалт амьжираагаа орхин, төв суурин уруу нүүхэд хүрч байна. 2007 оны байдлаар нийт суурин иргэдийн 38,5 хувь нь стандартын шаардлага бүрэн хангаагүй ус хэрэглэж байна.

2009 оны эцсийн байдлаар хүнс хөдөө аж ахуйн салбар 114,2 сая долларын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн. Улсын хэмжээнд авсан нийт зээлийн нэг хүнд ноогдох хэмжээ 550 ам.доллар болж байгаа бөгөөд үүнийг нэг хүнд ногдох орлоготой нь харьцуулахад зээлийн хамааралтай болсон.

2005 онд "Зохистой хоол хүнсээр хангагдах эрх"-ийн тайлан бичиж, зөвлөмж гаргасан хэдий ч түүний дагуу нөлөөллийн ажил хийгээгүй.

## МОНГОЛЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА

1. Монголын Улсын Үндсэн хуульд хүнсний эрхийг баталгаажуулах, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт энэ талаар тусгах;
2. Хүний эрхийг төлөөлөн нэхэмжлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
3. Хүнсний тухай хуулийг шинэчлэн батлахдаа хүнсний эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлэх, энэ чиглэлээр төрийн үүргийг тодорхойлох;
4. Монгол Улсад хүний эрхийг хамгаалах механизмыг бүрдүүлж буй байгууллагууд хараат бус бие даан ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэх, хүнсний эрхийг хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллах чадавхийг бэхжүүлэх;
5. Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн пактын хэрэгжилтийн IV тайланг олон нийтээр хэлэлцүүлэх замаар НҮБ-д илгээх (Мэдээлэл илгээх үед тайланг явуулаагүй байсан);
6. Хүнсний аюулгүй байдалд хяналт шалгалт хийдэг байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, чадавхижуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх;
7. Хүнсний аюулгүй байдлыг шалгах хөндлөнгийн, хараат бус лаборатори байгуулах;
8. Хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйл ажиллагааг дэмжих, хянах, техникийн туслалцаа үзүүлэх;
9. Малчид, тариаланчдын хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэх бэлтгэн нийлүүлэлтийн шударга тогтолцоог бий болгох;
10. Өрхийн аж ахуйг дэмжих, техникийн туслалцаа үзүүлэх;
11. Зээл тусламжийн үр нөлөөг сайжруулах, үүний тулд иргэний нийгмийн байгууллагууд хяналт үнэлгээ хийдэг эрх зүйн орчныг бий болгох.

# ДОЛООН САРЫН НЭГЭН БА ХҮНИЙ ЭРХ<sup>1</sup>

2008 оны Улсын Их Хурлын сонгуулийн албан ёсны дүн хараахан гараагүй байхад улс төрийн намаас хийсэн мэдэгдэл дургүйцсэн иргэд, иргэний хөдөлгөөн жагсаал цуглаан хийсэн. Иргэдийн үзэл бодлоо илэрхийлсэн цуглаан хяналтаас гарч нийтийн эмх замбараагүй байдалд хүрсэн бөгөөд «Онц байдал» зарласнаар 700 гаруй иргэнийг хоморголон баривчилж, «7 сарын 1-ний буюу Үймээн самууны хэрэг» хэмээн нэрлэгдсэн нэг гэмт хэрэгт 450 гаруй хүн сэжиглэгдэн шалгагдаж, 300-аад

хүн яллагдагчаар татагдан, 270 орчим иргэнийг шүүхээс 6 сараас 5 жилийн хугацаатай хорих ялаар шийтгэсэн юм. Онц байдал зарлах тухай Ерөнхийлөгчийн зарлигийг биелүүлэх явцад бүрэн биш тоогоор 20-иод хүн шархдаж, 4 хүн галт суманд хороогдож, 1 хүн угаартаж нас барсан. Энэ нь олон жил Монголын нийгэмд бугисан шүдэрга бус явдал, авилга, хээл хахуулийн үйлдэл, эс үйлдэлд дургүйцсэн нийгмийн тодорхой хэсгийн бухимдлын илрэл болсон гэж ТББ-ын Форум дүгнэж байна.

“7 сарын 1-ний буюу үймээн самууны хэрэг”-т холбогдсон иргэдийн хувьд:

- Амьд явах
- Халдашгүй дархан байх
- Тайван замаар жагсаал цуглаан хийх
- Θөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх
- Хараат бус, шударга шүүхээр шүүгдэх
- Эрүү шүүлтээс ангид байх зэрэг эрх нь ноцтойгоор зөрчигдсөн.

## ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ҮР ДАГАВАР

## КЭЙС<sup>2</sup>

Монгол Улсын иргэний амьд явах эрх ноцтой зөрчигдсөн.

Цагдаагийн ажилтнуудын бууны суманд өртөж амь наасаа алдсан нь тогтоогдсон ч цагдаагийн албан хаагч нарын хэргийг гэмт хэргийн бүрэлдхүүнгүй гэсэн үндэслэлээр, цагдаагийн дарга нарын хэргийг Өршөөл үзүүлэх тухай хуульд хамруулан тус тус хэрэгсэхгүй болгосон.

Монгол Улсын нэгдэн орсон гэрээ конвенциид дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх ажил хангалтгүй байсан.

- Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох эрх зүйн орчин бүрдээгүй.
- Жагсаал, цуглаан хийх тухай хуульд иргэний тайван замаар хийж буй “жагсаал цуглаан”-ыг “зөвшөөрөл” аваагүй тохиолдолд хууль бус үйлдэл хэмээн үзэж эрх чөлөөг нь хязгаарлахаар хуульчилсан.

- Иргэний болон улс төрийн эрхийн пактын ээлжит илтгэлээ цаг хугацаанд нь явуулдаггүй, НҮБ-ын гэрээний хороодоос гаргасан зөвлөмжийг сурталчлах, хэрэгжүүлэх ажил хийгддэггүй.
- Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг нь хязгаарлаж, хоморголон баривчилж, эрүүгийн хариуцлага хүүээлгэж байгааг эсэргүүцэн, чимээгүй суулт хийсэн хүмүүсийг “зөвшөөрөл” аваагүй хэмээх шалтгаанаар 14 хоног баривчлан хорьсон.
- Эрх зүйн чадамжгүй хүнээр “жагсаалд оролцсон, надад 1 сая төгрөг өгсөн” хэмээн гүүгэлгийн шинжтэй мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллээр удаа дараа нэвтрүүлсэн.

<sup>1</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг [www.upr-mongolia.mn](http://www.upr-mongolia.mn) вэб хуудаснаас үзнэ үү.

<sup>2</sup> Төрийн Бус Байгууллагудын Хүний Эрхийн Зөвлөлд илгээсэн мэдээлэлд тулгуурлан бэлтгэсэн тул нэмж тоо баримт, жишээ, тохиолдол оруулах боломжгүй байсан болно.

<p>Монгол Улсын нэгдэн орсон гэрээ конвенци, Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтыг ноцтой зөрчсөн.</p> <ul style="list-style-type: none"> <li>Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, баривчлагдсан даруйд нь төрөл саданд нь мэдэгдэгүй, баривчлах ажиллага шүүхийн хяналтад байгаагүй, гэрчид үүргийг сануулаагүй.</li> <li>Шүүх хууль бус арга хэрэглэн авсан нотлох баримтыг хавтаст хэргээс хасаагүй.</li> <li>Хүүхийн эрхийн конвенци болон Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн хэрэгт байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захиын жишиг дүрэм зөрчигдсөн.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Анхны мэдүүлгээ өмгөөлөгчтэй өгсөн нэг ч хүн байхгүй. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд заавал өмгөөлөгчтэй оролцох субъектүүдийг ч өмгөөлөгчгүйгээр байцаасан.</li> <li>Баривчлах ажиллагаанаас хойш 3-7 хоногийн дараа ч гэр бүлийн гишүүдээ хайсан 70 гаруй гэр бүл байсан.</li> <li>Нэг хэрэгт шийтгүүлсэн ялтан нь нөгөөгөө хамт явсан гэж гэрчилснээр шийтгүүлсэн.</li> <li>Баривчлах байранд цагдаагийн зодуур, айлан сурдуулгийн доор өөрийнхөө эсрэг өгсөн мэдүүлгээс өөр нотлох баримтгүй байхад шийтгэх, гэрч, хохирогчийн мэдүүлгийг нэгнээс нь хуулбарлан, дахин хувилсан материалыа хавтаст хэргийг нь бүрдүүлж ялласан.</li> <li>Насанд хүрээгүй хүүхдийг урт хугацааны хорих ялаар шийтгэх явдал түгээмэл гарсан.</li> </ul>
<p>Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийг нийгмийн хэв журам сахиулах ажиллагаанд дайчлан ажиллуулсан.</p>	<p>Хохирогчоор байцаагдсан мөрдөн байцаагч өөрөө яллагдагчийг байцааж, мэдүүлэг авч байсан.</p>
<ul style="list-style-type: none"> <li>Эрүүгийн байцаан шийтгэх хууль зөрчигдсөн.</li> </ul> <p>Хүний эрхийг хамгаалах механизмыг бүрдүүлдэг Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороо /ХЭДХ/, Хүний эрхийн үндэсний комисс /ХЭҮК/, Үндсэн хуулийн цэц үүргээ биелүүлж чадаагүй.</p> <ul style="list-style-type: none"> <li>Төрийн тодорхой институцээс хүний эрхийг зөрчих, эсхүл хамгаалах талаар тодорхой алхам хийгээгүй тохиолдолд зөрчигдсөн эрхийг сэргээх, буруутай этгээдэд хариуцлага тооцох хараат бус механизм байхгүйтэй адил байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ҮИХ-ын ХЭДХ нь аль намын гишүүн дийлэнх байгаагаас шалтгаалж, намын ашиг сонирхлыг илүүд үздэг болох нь үйл явдлын үеэр ажиглагдсан.</li> <li>Үндсэн Хуулийн Цэцэд дээд шүүхийн шийдвэрийг хянах эрх мэдэл өгөөгүй тул шүүх Үндсэн Хуулийг зөрчих боломжтой болсон.</li> <li>ХЭҮК-ын хууль нь түүний бие даасан хараат бус үйл ажиллагааг хангаагүй, Парисын зарчимд нийцээгүйн улмаас хүний эрхийг хангах, хамгаалах, нөхөн төлбөр олгоход анхаарч ажилладгагүй. ХЭҮК-ын дарга, гишүүдээр хүний эрхийн чиглэлээр ажиллаж байсан туршлагагүй хүмүүсийг улс төрийн томилгоогоор томилдог. Тиймээс ч “Онц байдал” зарласан үед “хүний эрх зөрчигдөөгүй” гэсэн хариуцлагагүй мэдэгдэл хийж, олон иргэдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндсэн шалтгаан нь болсон.</li> </ul>
<p>Шүүх шударга, хараат бусаар ажиллаж чадаагүй.</p> <ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын гурван шатны шүүх нийгмийн аюулгүй байдлыг хангах нэрийн доор хүний амьд явах, эрүү шүүлтээс ангид байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, гэм буруу нь тогтоогдоогүй нөхцөлд хэнийг ч гэм буруутайд тооцохгүй байх, өмгөөлөгчийн туслалцаа авах зэрэг суурь эрхийг зөрчөөд зогсохгүй, зөрчигдсөн эрхийг нь сэргээж чадаагүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Шүүх хуралдааныг 18 нас хүрээгүй хүүхдийн эрх ашгийг хамгаалах нэрийн доор хүүхэд, насанд хүрэгчдийг хамtruулан хаалттай хийж, хуулийг гажуудуулсан.</li> <li>Шүүх гэм буруутай эсэхийг тогтоох зарчмаасаа ухарч заавал буруутан болгох хандлага давамгайлсан.</li> <li>Мөрдөн байцаах явцад гэрчийн үүргийг сануулалгүйгээр, сэжигтийн мэдүүлэг өгөх эрхийг танилцуулж авсан мэдүүлгийг нотлох баримтын хэмжээнд үнэлсэн.</li> <li>Хүний эрхийн олон улсын гэрээнээс иш татсан өмгөөлөгчийн үйлчлүүлэгчид илүү хүнд ял шийтгэл оногдуулж байсан.</li> </ul>

#### МОНГОЛЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим заалтыг хүний эрхэд суурилан өөрчлөх;
- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд нэгдэж, хөндлөнгийн мониторинг хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх, үүнд тодорхой шаардлага хангасан ТББ-ыг хамруулах;
- Хүний эрхийг сэргээн хамгаалах тогтолцоо хангалтгүй байгаа учраас Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулж, хамгаалалтын тогтолцоог бий болгох;
- Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын ажилнуудын хүний эрхийн ойлголт, мэргэжлийн ур чадвар, чадавхийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;
- Хүний эрхийн үндэсний комиссын хуулийг Парисын зарчимтай нийцүүлэх, боловсон хүчинийг хүний эрхийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай хүмүүсээс бүрдүүлэх болон
- Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын ажлыг дүгнэх механизмыг хүний эрхэд суурилан өөрчлөх нь зүйтэй.

# ШИЛЖИН СУУРЬШИГСДЫН ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ<sup>1</sup>



**M**анай улсын хууль тогтоомжид дотоод болон гадаад шилжилт хөдөлгөөний талаар зохицуулалт байгаа хэдий ч шилжин суурьшигсдад ээлтэй бодлогын баримт бичиг байхгүйн улмаас тэд Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ, Үндсэн хуулиар олгогдсон үндсэн эрх, эрх чөлөөгөө эдэлж чадахгүйд хүрч байна.

Ялангуяа зохицтой орон байраар хангагдах, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох, сонгох эрх нь зөрчигдсөөр байна. Түүнчлэн дүрвэгсдийн асуудлыг зохицуулсан олон улсын гэрээ конвенциид нэгдэн ороогүйгээс орогнол хүссэн иргэдтэй холбоотой асуудлыг зохицуулахад хүндэрэг үүсдэг.

## Шилжин суурьшигсад, цагаач иргэдийн хувьд:

- Эрүүл аюулгүй орчинд амьдрах
- Зохицтой орон байраар хангагдах
- Эрүүл мэндээ хамгаалуулах
- Сурч боловсрох
- Сонгох
- Хөдөлмөрлөх
- Газар өмчлөх
- Угуул нутагтаа амьдрах
- Уламжлалт аж ахуйгаа эрхлэх зэрэг эрхүүд нь түгээмэл зөрчигдэх байна.

## ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ҮР ДАГАВАР

Цагаач иргэд болон дүрвэгсдийн асуудлыг зохицуулах эрх зүйн орчин байхгүй. Олон улсын гэрээ конвенциид нэгдэн ороогүй.

- Дүрвэгсдийн эрх ашгийг хангах хамгаалах нөхцөл бүрдээгүй, тэдний талаар мэдээ мэдээлэл хаалттай бөгөөд олон улсын заншлын хэм хэмжээг зөрчих явдал гардаг. Дүрвэгсдтэй ажиллах боломж хүний эрхийн байгууллагуудад хаалттай байна.
- Цагаач иргэд болон тэдний гэр бүлийн эрх ашиг зөрчигдөх эрсдэл байна.

## КЭЙС<sup>1</sup>

- 2009 онд орогнол хүссэн өвөрмонгол иргэнийг бичиг баримтыг нь шалгах явцдаа эх орон руу нь албадан буцаасан.
- Хойд Солонгосын иргэд Монгол Улсад дүрвэж ирэх явдал байдаг ч Засгийн газраас хөрөнгө гаргадаггүй, зөвхөн олон улсын байгууллагын дэмжлэгээр зохицуулагддаг.
- Монгол Улсаас дүрвэн гарч байгаа иргэдийн талаар статистик мэдээлэл байхгүй.
- 2008 оны байдлаар Монгол Улсад 106 орны 38,000 орчим гадаадын болон харьяалалгүй иргэн байна.

Улс хоорондын гэрээний биелэлтэд хяналт тавьдаггүй.

- Хөдөлмөр хамгааллын журам зөрчигдөж, гадаад улсад хөдөлмөр эрхэлж буй хүн эрүүл мэнд, амь насаараа хохирох явдал гарсаар байна.

Эрүүл монгол хүнийг сонгон явуулдаг ч 3-5 жилийн дараа ямар нэг өвчтэй болж ирдэг. 2004-2007 онд Бүгд Найрамдах Солонгос улсад ажиллаж буй иргэдээс 326 хүн амь насаа алдсан.

<sup>1</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг [www.upr-mongolia.mn](http://www.upr-mongolia.mn) вэб хуудаснаас үзнэ үү.

<sup>2</sup> Төрийн Бус Байгууллагудын Хүний Эрхийн Зөвлөлд илгээсэн мэдээлэлд тулгуурлан бэлтгэсэн тул нэмж тоо баримт, жишээ, тохиолдол оруулах боломжгүй байсан болно.

Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг хөдөө нутгийн хамгийн соргог, шимт ургамал бүхий малын бэлчээр, элбэг тунгалаг усны эх голыг даган олгодог.

- Малчдын уламжлалт мал аж ахуйгаа эрхлэх, төрж өссөн нутагтаа амьдрах нөхцөлгүй болгож байна.

Байгаль, цаг агаарын гамшигт үзэгдлийн давтамж олишрч, түүнээс учрах хохирлын хэмжээ их болж байна. Мөн газар нутгийн ихэнх нь хуурайшилт, цөлжилт, хөрс усны доройтолд өртөж, бэлчээрийн ургац муудаж байна.

- Амьжиргааны эх үүсвэрээсээ салсан хөдөөгийн иргэд төв суурин барагдан нүүхэд хүрч байна.

Дотоод шилжилт хөдөлгөөнийг зохицуулсан нэгдсэн бодлого, нийгэм, эдийн засгийн талаар тэдэнд зориулсан ямар нэг төлөвлөгөө, зохион байгуулалт байхгүй.

- Шилжин суурьшигсдын хүний эрхийн гэрээ конвенци, Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндсэн эрх, эрх чөлөө нь зөрчигдөхөд хүрч байна.
- Нийт шилжин суурьшигсдын 39,1 хувь нийслэлд төвлөрч байгаа нь хотын нийгэм, эдийн засаг, засаг захиргааны нэгжийн ачааллыг нэмэгдүүлж байна.
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн ачаалал нэмэгдэх, сургалтын хүртээмж, чанар буурах, багш нар хүүхдүүдэд ялгавартай хандах зэрэг зөрчлийг дагуулдаг.

- Сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, амьжиргаагаа дээшлүүлэх боломжийг эрэлхийлж төв суурин уруу шилжин суурьших урсгалыг эрчимжүүлж байна.

Гадаадад шилжин суурьшигсад, тэдний хүүхдийн асуудлыг бүхэлд нь зохицуулсан бодлого байхгүй.

- Гэр бүлийг тусдаа амьдрах, хүүхэд эцэг эхийн хайр халамжид амьдрах боломжийг хааж байна.

- Цэвэр усны хангамжгүй, муу ус, бохирын шугамгүй, цахилгаангүй орчинд амьдарч байна.
- Бичиг баримт авахад шат дамжлага олон, торгуул өндөр, олгох хугацаа нь урт байдгаас шилжин суурьшигсдын бүртгэлд хамрагдалт удааширдаг. Үүний улмаас газар өмчлөх, зохистой орон байраар хангагдах, сонгох, эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөрлөх эрх нь зөрчигдөхөд хүрдэг.
- Ихэнх нь орцны манаач хийж голоо зогоодог.
- Шилжин суурьшигсдын гуравны нэг нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байдаг.
- Шилжилт хөдөлгөөн нь төвлөрсөн газрын сургуулийн анги дүүргэлтийг эрс нэмэгдүүлж, З ээлжээр нэг ангидaa 40-53 хүүхдтэй хичээллэх тохиолдол гарч байна. Бүртгэлгүй гэсэн шалтгаанаар шилжин суурьшигсдын хүүхдийн 33,3 хувь нь сургууль завсарддаг. Хол гэртэй хүүхдүүд 3-4 км явган явж сургуульдаа хүрдэг.

Эцэг эхийн хайр халамж, хараа хяналтаас тусдаа байгаа хүүхдүүд сургууль завсардах, гэмт хэрэг, зөрчилд холбогдох явдал түгээмэл гардаг.

Гадаадаас сайн дураар ирж буй болон албадан ирүүлж буй монгол иргэдэд чиглэсэн нэгдсэн бодлого байхгүй байна.

- Эргэн нийгэмших, ажилд ороход нь хүндрэл учирдаг.
- Албадан эх оронд нь ирүүлэх үед хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдөх үзэгдэл түгээмэл гардаг.

Эх нутагтаа ирээд нийгэмшиж чадаагүй хүмүүс гадаадад дахин гарах оролдлого хийх, тэр дундаа хууль бус үйлдлийг ч хийхэд хүрдэг бөгөөд ингэснээр өөрсдийгөө хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болгох, хар тамхи, мансуруулах бодис зөөвөрлөх гэмт хэрэгт холбогдох зэрэг эрсдэлтэй байдалд оруулдаг.

## МОНГОЛЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

1. Дотоод болон гадаад шилжилт хөдөлгөөн, түүнээс гарах үр дагавраас урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх асуудлыг багтаасан шилжилт хөдөлгөөнийг нэгдсэн байдлаар зохицуулах бодлогын шинжтэй баримт бичиг боловсруулан, хэрэгжүүлэх;
2. Гадаад улсад шилжин суурьшиж буй Монголчуудын эрх ашгийг хамгаалах, нэгдсэн бүртгэл, мэдээллийн бааз бүрдүүлэх, уг харилцаатай холбоотой дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох;
3. Монголчууд олноор ажиллаж амьдарч буй орнуудтай иргэний давхар харьялалт бий болгох талаар судлах, тус орнуудын элчин сайдын яамны дэргэд хүний эрхийн асуудал хариуцсан атташе ажиллуулах;
4. "Цагаач ажилчид ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах" тухай НҮБ-ын конвенциид нэгдэн орох болон
5. Дүрвэгсдийн талаар мэдээ баримтыг олон нийт, хүний эрхийн байгууллагуудад нээлттэй болгох нь зүйтэй.

# МОНГОЛЫН ЦӨӨНХИЙН ТАЙЛАН<sup>1</sup>

Монголын нийгэмд тодорхой хувийг эзлэх үндэстний цөөнх, бэлгийн цөөнх, ХДХВ/ДОХ-той хүмүүс, биеэ үнэлэгч гэсэн бүлгүүдийн талаар нийгэмд буруу ойлголт, сөрөг хандлага түгээмэл байдгийн улмаас бүрэн хүлээн зөвшөөрөгдөж чаддаггүй бөгөөд ялгаварлан гадуурхалтад өртөж, суурь эрх, эрх чөлөөгөө бүрэн эдэлж чадахгүй байна. Түүнчлэн эдгээр бүлгийн эрхийг хангах, хамгаалах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд нөхөн сэргээх хууль эрх зүйн орчин хангалтгүй, хүртээмжгүй бөгөөд

ул ялгаварлан гадуурхагдах эрхийг нь хэрэгжүүлэх хуулийн тогтолцоо, хэрэгжүүлэх механизм байхгүй байна. Үүний улмаас цөөнхийн бүлэг дунд дарамт, алагчлал, хүчирхийлэл, үзэн ядлын гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг, хүний наймаа зэрэгт өртөх, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байх, хөдөлмөрлөх эрх нь зөрчигдөх, хувийн нууц алдагдах, эрүүл мэндийн байдал, хүйсийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхагдах зэрэг явдал элбэг гардаг.

## ЦӨӨНХИЙН БҮЛГИЙН ХУВЬД:

- Ялгаварлан гадуурхагдахгүй байх
- Эх хэлээрээ сурч боловсрох, мэдээллийг эх хэлээрээ олж авах, түгээх
- Уламжлалт соёл, зан заншлаа хадгалах, хойч үедээ өвлүүлэх
- Иргэний харьялалтай байх
- Эрүүл мэндээ хамгаалуулах
- Халдашгүй дархан байх
- Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох зэрэг эрхүүд нь зөрчигдэж байна.

## ЦӨӨНХИЙН ТУЛГАМДАЖ БҮЛГИЙН АСУУДАЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ҮР ДАГАВАР<sup>2</sup>

### Үндэстний цөөнх

Бодлого боловсруулах түвшинд төлөөлөл бага, ялангуяа цаатнууд ямар ч төлөөлөлгүй.

- Цөөнхийн эрх ашгийг бодлого шийдвэрт тусгадаггүй, тэдэнд чиглэн гарсан бодлого хэрэгждэггүй.
- Социализмын үеэс улбаатай олонхийн соёлыг цөөнхөд тулгах хандлага хэвээр байна.

Эх хэлээрээ сурч боловсрох эрхийг хангах бодлогын хэрэгжилт хангалтгүй.

- Цөөнх төвт боловсролын бодлого байхгүй бөгөөд энэ байдал нь тэдний сурч боловсроход сөргөөр нөлөөлж, сурч боловсрох үндсэн эрх нь зөрчигдхөд хүрч байна.
- Үндэстний цөөнхийн хэл дээр боловсрол олгох боловсон хүчин дутмаг, ном сурах бичиг хүрэлцээгүй.

Үндэстний цөөнх эх хэлээрээ мэдээлэл олж авах, түгээх эрх зүйн зохицуулалт байгаа хэдий ч хэрэгжилт хангалтгүй.

- Үндэстний цөөнх, тэр дундаа казах хэл дээр тогтмол хэвлэл, телевиз радиогийн хөтөлбөр байхгүй.
- Олон нийтийн радио телевизийн тухай хуульд үндэстний цөөнхийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангахаар заасан ч хэрэгждэггүй.

Цаатнуудын амь зуулгын арга хэлбэрийг хуулиар үгүй хийж байна.

- Уугул болон овог аймгийн тодорхойлолтод бүрэн багтах цаатан/духа иргэд тусгай эрхээр хангагдаж, хамгаалагдаагүйн улмаас тэдний ан агуураар амьдардаг амь зуулгын арга хэлбэрийг Ан агуурын тухай хууль тогтоомжоор бараг үгүй хийсэн.

Үндэстний цөөнх казах хүмүүсийн иргэний харьялалтай байх эрх зөрчигдэж байна.

- 1990 оноос Казахстан уруу олноороо шилжин суурьших болсонтой холбоотойгоор харьялалгүй болсон казах хүмүүс их байна.

<sup>1</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг [www.upr-mongolia.mn](http://www.upr-mongolia.mn) вэб хуудаснаас үзнэ үү.

<sup>2</sup> Төрийн Бус Байгууллагудын Хүний Эрхийн Зөвлөлд илгээсэн мэдээлэлд тулгуурлан бэлтгэсэн тул нэмж тоо баримт, жишээ, тохиолдол оруулах боломжгүй байсан болно.

Бэлгийн цөөнх	Бэлгийн цөөнхийг үл ялгаварлах тухай хууль, эрх зүйн хамгаалалт байхгүй.
	<ul style="list-style-type: none"> <li>Цагдаа, шүүх, эрүүл мэнд, боловсрол, хэвлэл мэдээллийн байгууллага, гэр бүл бүхий л хүрээнд ялгаварлагддаг.</li> <li>Халдашгүй дархан байх, тайван замаар эвлэлдэн нэгдэх, боловсрол болон мэдээлэл хүртэх, хүрэлцэхүйц амьжиргааны орлоготой байх, хөдөлмөрлөх, эрүүл мэндийн жишиг стандартын үйлчилгээ хүртэх, гэрлэх эрхүүд нь зөрчигдэх байна.</li> <li>Ажлын байрны дарамт, бие ба бэлгийн хүчирхийлэлд өртөх, үзэн ядлаас үүдэлтэй гэмт хэргийн золиос болох тохиолдолд элбэг гардаг.</li> </ul>
ХДХВ/ДОХ-той хүмүүс	<p>ХДХВ-ийн халдварт авсан хүмүүсийн байдал буюу тэдний хувийн мэдээллийг чандлан нууцлах зарчмын хэрэгжилт дутмаг. Үндсэн хуульд ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүсийг эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхахгүй гэсэн заалт тусгагдаагүй. Эрүүл мэндийн тухай хууль, ХДХВ/ДОХ-аас сэргийлэх хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн заалтууд зөрчилдөөнтэй.</p> <ul style="list-style-type: none"> <li>Ажилд ороход заавал ХДХВ/ДОХ-ын шинжилгээ өгөхийг шаарддаг нь ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн ажил мэргэжлээ сонгох эрхийг ноцтой зөрчиж байна. Одоогийн байдлаар ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн 27 хувь нь ажилтай, 20 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, үлдсэн хувь нь ажилгүй байна.</li> <li>Эрүүл мэндийн хуулинд нийтэд аюултай онцлог халдварт өвчин нь эрүүл мэндийн нууцад хамрахгүй гэсэн бөгөөд ХДХВ/ДОХ-ын халдварт үүнд багтах эсэх нь тодорхойгүй.</li> <li>Өөрийн хамтран амьдрягч, эхнэр/нөхөрт нэн даруй мэдэгдэх, эмнэлгийн тусламж аваадаа эрүүл мэндийн байгууллагад заавал мэдэгдэх зэрэг заалт нь Хувь хүний нууцын тухай хуулийн "хувь хүн нууцаа өөрөө хамгаална" гэсэн заалттай зөрчилдэх байна. Үүний улмаас хувь хүний мэдээллийн нууц алдагдаж, ялгаварлан гадуурхагдах, бусад эрх нь зөрчигдөхөд хүргэж байна.</li> </ul>

Биеэ үнэлэгч	<p>Нийгэм, олон нийт биеэ үнэлэгчдийн талаар сөрөг хандлагатай, Садар самуунтай тэмцэх тухай хуулиар биеэ үнэлэгчийг хориглосон зэргээс убаалан эдгээр бүлэг хүмүүс ялгаварлан гадуурхалт, хэл ам, бие болон бэлгийн хүчирхийлэлд өртөж, аль болохоор нуугдаж амьдрахад хүрч байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>Үйлчлүүлэгчдийн зүгээс хэл амаар доромжуулах, зодуулах, амь насаа алдах халдлагад өртөх, улмаар бэлгийн мөлжлөгө, хил дамнан худалдагдах эрсдэлд ч ордог.</li> <li>Цагдаад торгуулах, түр саатуулагдахын зэрэгцээ бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртдэг.</li> <li>Биеэ үнэлэгчдийн дунд ирээдүйдээ итгэх итгэлгүй болох, өөрийгөө буруутгах, айж ичих, гутрах, өөрийгөө гаргуунд гаргах зэрэг нийгэм, сэтгэлзүйн сөрөг илрэл түгээмэл тохиолддог.</li> </ul>
--------------	---

## МОНГОЛЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

- Алагчлалын эсрэг хууль боловсруулж, батлах, хэрэгжилтийг хянах механизмыг бүрдүүлэх;
- Үндэстний цөөнх:** Бодлого боловсруулах түвшинд цөөнхийн оролцоог хангах механизмуудыг бүрдүүлж, тэдэнд чиглэсэн боловсролын бодлого боловсруулан хэрэгжүүлэх; Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 169-р конвенциид нэгдэн орж, цөөнхийн тусгай эрхийг хангах, хамгаалах; цөөнхийн харьяаллын асуудлыг нэн даруй шийдвэрлэх; Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, Олон нийтийн радио телевизийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд үндэстний цөөнхийн хэл дээр тодорхой тооны радио, телевизийн нэвтрүүлэг тогтмол бэлтгэн гаргах, цөөнхийн хэл дээрх хэвлэн нийтлэлийг хөхиулэн дэмжихийг төсвөөс хангах; Олон нийтийн баримт мэдээлэл, тэр дундаа бодлогын холбогдол бүхий баримт бичгийг үндэстний цөөнхийн хэл рүү орчуулах зэрэг арга хэмжээ авах;
- Бэлгийн цөөнх:** Гэрлэлтийн тэгш байдалд тусгайлан анхаарч, олон улсын гэрээний өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу ижил хүйсийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрөх; Үзэн ядлаас үүдсэн гэмт хэргийн хууль боловсруулан гаргаж, ийм гэмт хэргийн хохирогчийн хохирлыг нэн даруй эрүү, иргэн, захирагааны шүүхээр шийдвэрлүүлэх механизмыг бүрдүүлэх; Хувийн нууцыг хадгалах, боловсрол, мэдлэг, харилцан ойлголцлыг хөхиулэн дэмжих; Лесби, Гей, Бисекс, Трансжендер (ЛГБТ) хүмүүсийн бэлгийн болон хүйсийн чиг баримжаанд үндэслэн байнга тагнаан мөрдөх үйл ажиллагааг зогсоох, хувийн хүрээний захидал, харилцааны нууцад халдаж, эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхийг нь шууд болон шууд бусаар хөндөж буй шалтгаан, шалтуураа нээлттэй мэдэгдэх;
- ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүс:** Ажлын байранд үл ялгаварлах талаар нэмэлт өөрчлөлтийг Хөдөлмөрийн хуулинд тусгах; Хувь хүний нууцыг чандлан хамгаалах зарчмыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх болон;
- Биеэ үнэлэгч хүмүүс:** Биеэ үнэлэгчийг гэмт хэргийн тооноос хасч, үйлчлүүлэгч хүмүүст хариуцлага тооцох арга хэмжээг авах; Биеэ үнэлэгч хүмүүст хууль эрх зүйн мэдлэг олгох, эрхээ хамгаалахад нь туслах, санхүүгийн өөр эх үүсвэртэй болоход нь дэмжлэг туслалцаа үзүүлэх нь зүйтэй.

# МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ ТББ-ЫН ФОРУМЫН НЭГДСЭН ИЛТГЭЛ<sup>1</sup>

Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын хүний эрхийн ихэнх гэрээ, конвенцийн нэгдэн орсон боловч олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, тайлангаа цаг хугацаанд нь явуулах, ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тун хангалтгүй ажиллаж байна. Монгол Улсын нэгдэн

орсон хүний эрхийн олон улсын гэрээ конвенцийн заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдвэл шүүхэд голдол гаргах эрхтэй ч тухайн заалт нь холбогдох хуулиудад зохих тусгалаа олоогүй, эсвэл шүүгчдийн мэдлэг чадвар хангалтгүйгээс шүүхийн практикт нэвтрэхгүй байна.

## ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Эрх зүйн орчин, Хүний эрх, эрх чөлөөг ханган, хамгаалахад шаардлагатай олон чухал хууль, хуулийн заалт байхгүй байна. Хэрэгжилт Үүнд:

- Хохирогч/гэрчийг хамгаалах хууль, хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хууль, иргэдийн оролцооны эрхийг хангах хууль, жендерийн тэгш байдлыг хангах, жендерт сууринсан хүчирхийлэлтэй тэмцэх хууль, хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакцийн хараат бус байдлыг хангах хууль, Улсын Их Хурлын гишүүдтэй хариуцлага тооцох, тэдний ёс зүйн дүрэм, нийтийн эрх ашгийг нэхэмжлэх, хуулийн хэрэгжилтийг хянахад иргэний нийгмийн оролцоог хангах зэрэг асуудлаар хуулийн зохицуулалт байхгүй байна.

Хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхдэд зарим хууль сөрөг нөлөө үзүүлдэг. Үүнд:

- Нууцын тухай багц хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Онц байдлын тухай хууль, Шүүхийн тухай хууль, ТББ-ын бүртгэл, татвар, нийгмийн даатгалтай холбоотой хуулийн зарим заалтууд, Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлэх журмын тухай хууль, сонгуулийн багц хууль, Улс төрийн намын тухай хууль болон дур зоргоор гаргадаг захиргааны журам зэрэг нь хүний эрхийг ханган, хэрэгжүүлэхдэд тодорхой хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлж байна.

Зарим хууль, хуулийн заалтуудын хэрэгжилт муу. Үүнд:

- Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль, Эрүүгийн хуулийн хүн худалдах гэмт хэргийн заалтууд, Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль зэргийг дурьдаж болно.

Хүний эрхийг хамгаалах үндэсний механизмын

Монгол Улсад хүний эрхийг хангаж, хамгаалахаар байгуулсан үндэсний бүтэц, механизмын хувь нь хүний эрхийн хэрэгжилтийн баталгаа болж чадахгүй байна. Үүнд:

- УИХ-дахь Хүний эрхийн дэд хороо хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах хяналт, шалгарт хийх эрхийг хэрэгжүүлэх үүрэгтэй ч үүргээ биелүүлдэггүй, УИХ-ын баталсан хууль, тогтоол, хөгжлийн баримт бичиг, шийдвэрт хүний эрхийн дүгнэлт хийдэггүй. Хийх эрмэлзэл ажиллагааг хангаагүй, чадавхи ч байхгүй.
- Хүний эрхийн үндэсний комиссын хууль нь түүний бие даасан хараат бус үйл ажиллагааг хангаагүй, Парисын зарчимд нийцээгүйн улмаас хүний эрхийг хамгаалах тал дээр дорвitoй алхам хийх чадавхигүй байна.
- Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг олон нийтийн өргөн оролцоотой боловсруулан баталж, хэрэгжүүлэх Үндэсний хороог Ерөнхий сайдаар ахлуулж, түүний Ажлын алба, орон нутгийн салбар хороог байгуулсан. Гэвч хөтөлбөрийг хэрэгжүүлэхгүй, хөтөлбөрт өөрт нь байгаа хяналтын механизмыг ажиллуулахгүй, хэрэгжүүлэх чиглэлээр улсын төсвөөс хангалттай санхүүжилт өгөхгүй, хэрэгжилтийг үнэлэхгүй байгаагаас үр нөлөө нь бага байна.
- Засгийн газар хүний эрхийг хангах, хамгаалах үүрэг хүлээдэг ч үйл ажиллагаандаа хүний эрхийн үүднээс дүгнэлт хийдэггүй, харин орон нутгийн захиргаа, иргэдийн хуралд энэ талын үүрэг хариуцлага хүлээнэ гэсэн заалт ч байхгүй байна. Тиймээс хүний эрхэд сууринсан хандлага засгийн газар, орон нутгийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн мониторинг, үнэлгээнд нэвтрэхгүй байна. Хуулийн хэрэгжилтийг хянахдаа хүний эрхийн асуудлыг орхигдуулсаар байна.
- Шүүхийн хараат бус байдал алдагдсан нь түүний бүтэц, тогтолцоо, ёс зүйн асуудалтай холбоотой. Шүүгчид тогтолцоо, эрх мэдлийн дарамтаас болж хараат бус байдлаа алдахын зэрэгцээ, авлигад автан ёс зүйгүй ажилладаг.

- Хүний эрхийн чиглэлээр идэвхийтэй ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын тогтвортой үйл ажиллагааг хангах эрх зүй, санхүүжилт, мэдээллийн орчин бүрдээгүй. Иргэний нийгмийн тогтвортой үйл ажиллагааг хангах төрийн бодлого ч байхгүй. Тиймээс иргэний нийгмийн байгууллага нь гадны санхүүжилтээр, богино хугацааны төсөл хэрэгжүүлэхээр үйл ажиллагаа нь хязгаарлагдаж, хууль, бодлогод чиглэсэн үр дүнтэй нөлөөлөл хийх боломжгүй болж байна. Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах, хуулийн хэрэгжилтийн хяналтад эрх зүйн үр дагавартай оролцох эрх зүйн орчин байхгүй байна.

Зөрчигдэх буй эрхүүд	<ul style="list-style-type: none"> <li>Иргэд иргэний, улс төрийн эрхээ тэгш, бүрэн дүүрэн эдэлж чадахгүй, улмаар иргэдийн ардчилсан арга замаар өөрөө өөрийгөө удирдах эрх зөрчигдэх байна.</li> <li>Ядуурал, уул уурхайн салбарын үйл ажиллагааны улмаас хүний эрхийн өргөн хүрээний зөрчил гарч байна. Үүнд: Хүн амын 35,2 хувь ядуугаас гадна ядуучуудын дунд ажилтай ядуучууд нилээд хувийг эзэлдэг. Зохистой орон байраар хангагдах эрх, хөдөлмөрлөх, амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангахуйц хөлс авах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, соёл уламжлалаа хадгалан үлдэх, зохистой, хүрэлцэхуйц амьжиргаатай байх, амьжиргааны арга барилаа чөлөөтэй сонгох, газар зээмших, ашиглах, өмчлөх, мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад оролцох, хөгжилд оролцож, үр шимиийг нь хүртэх, нийгмийн халамж үйлчилгээ хүртэх, сурч боловсрох, ундны цэвэр усаар хангагдах, шударга шүүхээр шүүлгэх зэрэг эрхүүд түгээмэл зөрчигдэх байна.</li> </ul>
Бусад асуудал	<ul style="list-style-type: none"> <li>Олон саяар үнэлэгдэх хөгжлийн зээл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч төдийлөн үр дүнгээ өгөхгүй байна. Тус хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад иргэд, тэр дундаа яду хүмүүс, орон нутгийн хүмүүсийг оролцуулдаггүй. Ихэнх мэдээлэл монгол хэл дээр байдаггүй, хүртээмж муу тул иргэд хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, хяналтад оролцож, үр шимиийг нь хүртэн хөгжих эрхээ өдэлж чадахгүй байна.</li> <li>Орон нутгийн иргэний нийгмийн байгууллага мэдээлэл, санхүүжилт байхгүйн улмаас хөгжихгүй, үүнээс үдэн орон нутагт их хэмжээний зээл, тусlamжийн хөтөлбөрүүд олон нийтийн хяналтгүйгээр, үр дүн муутай хэрэгжиж байна.</li> </ul>

## МОНГОЛЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

- Хүний эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа хууль, хуулийн заалтыг бий болгох, сөргөөр нөлөөлж буй хууль, захиргааны журмуудыг өөрчлөх, хэрэгжилт нь хангалтгүй байгаа хууль, хуулийн заалтыг хүний эрхийн үүднээс иргэний нийгмийн оролцоотой дүгнэдэг болох, шүүгчдийн хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлж, олон улсын гэрээ конвенции, Үндсэн Хуульд заасан хүний эрх, эрх чөлөөний заалтыг шүүхийн практикт ашиглах чадавхитай болгох замаар эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- УИХ дахь Хүний эрхийн дэд хороо холбогдо баримт бичгүүдэд хүний эрхийн дүгнэлт хийдэг болох, энэ чиглэлээр чадавхия бэхжүүлэх, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг Парисын зарчимд нийцүүлэх, гишүүнний шалгурту хүний эрхийн мэдлэг туршлагыг чухалчлах, иргэний нийгмийн байгууллагад нийтийн эрх ашгийг нэхэмжлэх, хуулийн хэрэгжилтэд тавих хяналтад эрх зүйн үр дагавартай оролцох эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон талын оролцоог хангаж, хамтын ажиллагааг хөгжүүлэх, шүүхийн хараат бус байдлыг хангаж, шүүгчийн ёс зүйг чандлан сахих механизмыг бүрдүүлж, шүүгчийн шалгур, томилгоог өөрчлөх зэргээр хүний эрхийг хамгаалах үндэсний бүтэц, механизмыг бэхжүүлэх;
- Засгийн Газар ядуурлыг хүний эрхийн зөрчил хэмээн үзэж, түүнийг бууруулах, арилгах чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг оновчтой зохицуулах, эрхэд суурилсан ялангуяа ядуу иргэдийн оролцоог хангасан хөгжлийн бодлого төлөвлөх аргачлалд суралцах, боловсруулж хэрэгжүүлэх, жижиг оврын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөгжлийн зээл, туслалцааны хөтөлбөрүүдийг эмзэг бүлгийнхэнд чиглүүлэх, гадаадын зээл тусламжийн хэрэгжилтэд иргэдийн хяналтыг бий болгох, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн олон улсын пакт болон түүнийг хэрэгжүүлэх талаар Эдийн засаг нийгэм соёлын эрхийн Хорооноос өгсөн дүгнэлт зөвлөмж, ядуурлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчдийн өгсөн зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлдэг болох болон
- Иргэдийн байгаль орчны эрхийг хэрэгжүүлж, түүнтэй холбоотой бусад олон эрх зөрчигдхөөс сэргийлэхийн тулд Аархусын конвенциид нэгдэн орох, "Угуул иргэдийн эрхийн тухай" НҮБ-ын тунхаглалд үндэсний хууль тогтоомж, байгаль орчны бүх хуулиудыг нийцүүлэх, иргэдийн оролцоо, хяналт тавих механизмыг хуульчлах, хотын агаарын бохирдлыг бууруулах төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад хөндлөнгийн мониторинг хийлгэх, Засгийн Газрын 86-р тогтоолыг хүчингүй болгох, хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрт байгаль орчин, нийгмийн серег нөлөөллийн үнэлгээ хийх эрх зүйн орчин бүрдүүлж, үнэлгээг олон улсын стандартын дагуу хийлгэдэг болох, байгаль орчны дагнасан шүүх, цагдаа прокурорт хэлтэс, тасаг байгуулах, байгаль орчны хохирол, нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлэх, Хонгор сумын иргэдэд учирсан хохирлыг хараат бус хөндлөнгийн шинжээчдээр дахин нягтлан тодорхойлуулж, төрөөс нөхөн төлбөрийг нэн даруй олгох нь зүйтэй.
- Түүнчлэн өдгөө зөвлөмжийг хэрэгжүүлэхэд Засгийн Газарт техник, санхүүгийн туслалцаа хэрэгтэй болохыг тэмдэглэж байна.

# ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ БА ХҮНИЙ ЭРХ<sup>1</sup>

Монгол Улс 1990-ээд оны эхээр нам төвтэй төвлөрсөн тогтолцооноос арчилал, зах зээлийн нийгэмд шилжиж, иргэд гадаадад чөлөөтэй зорчих болсон нь олон сайхан боломжийг нээсэн хэдий ч зарим сөрөг үзэгдлийг мөн дагуулсан. Тухайлбал, хүн худалдаалах, ялангуяа охид эмэгтэйчүүдийг худалдаалах гэмт хэрэг шинээр гарах болсон бөгөөд сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэрэг нэмэгдэж, бэлгийн болон хөдөлмөрийн

мөлжлэг, захиалгат гэрлэлт гэсэн хэлбэрээр голчлон үйлдэгдэж байна. 2001 онд хүн худалдаалах гэмт хэргийн нэг гаралт байсан бол 2008 оны байдлаар 300 гаруй хэрэг бүртгэгдэж, шалгагдсан байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь ихэвчлэн охид, залуу эмэгтэйчүүд байна. Судлагдсан эрүүгийн хэргийн хохирогчдын 30 хувь нь 18-21 наасны, 20 хувь нь 21-26 наасны, 11 хувь нь насанд хүрээгүй эмэгтэйчүүд байсан.

## Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын хувьд:

- Боопчолоос ангид байх
- Сайн дурын үндсэн дээр гэрлэх
- Хөдөлмөрлөх
- Халдашгүй дархан байх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хохирлоо нөхөн төлүүлэх
- Шударга шүүхээр шүүлгэх эрх түгээмэл зөрчигдэх байна.

## ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ҮРДАГАВАР

Палермогийн протоколын хэрэгжилт хангалтгүй. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, гэрчийг хамгаалах эрх зүйн орчин байхгүйтэй адил байна. Мөн сэтгэл санааны хохирлыг тооцох тогтолцоо, эрх зүйн орчин байхгүй.

- Хохирогчийг хамгаалахаас гадна, нэр төрийг нь сэргээх, эргэн нийгэмшихэд нь зориулж төрийн зүгээс тодорхой ажил хийхгүй байна.
- Гэрч, хохирогч нь эрх зүйн хамгаалалтын гадна үлдэж, гэмт хэрэгтний дарамт, айлан сурдүүлэлтэд өртөж, сэтгэл санааны давхар хохирол амсаадад хүрч байна.

Монгол Улс 2008 онд Эрүүгийн хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулж, мөн онд Улсын дээд шүүхээс тайлбар хийснээр хүн худалдаалах гэмт хэргийг олон улсын үзрээ конвенцийн зарчимд нийцүүлэн хуульчилж өгсөн ч шүүхийн практикт эрүүгийн хуулийн зүйл ангийг буруу хэрэглэх, прокурорын шатанд хэрэгсэхгүй болгох нь түгээмэл байна.

- Хохирогч давхар хохирон үлдэж, гэмт хэрэгтэнд ял завших боломжийг олгож байна.

## КЭЙС<sup>2</sup>

Монголд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хоёр хохирогч гэмт хэрэгтний ятгалга, айлан сурдүүлэлтэд автаж, мэдүүлгээсээ буцан, улмаар хуурамч мэдүүлэг өгсөн хэрэгэр ял шийтгэгдсэн.

Эрүүгийн хуулийн 113-р зүйл "Хүн худалдаалах" гэсэн онц хүнд гэмт хэргийн зүйл ангиар бус 124 буюу "биэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах" гэсэн хөнгөн зүйл ангиар шийтгэж, ял завшуулж байна. Мөрдөн байцаалтаас прокурорын шатанд 2004-2008 онд ирсэн хэргүүдийн 85-90 хувийг "дуулах, бүжиглэхийн зэрэгцээ үйлчлүүлэгч хүсвэл бэлгийн харьцаанд орно гэдгээ мэдэж байсан учир хүчинд автагдсан, хууран мэхлэгдсэн гэх үндэслэлгүй", "хангалттай нотлох баримтгүй" зэрэг үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон байна. 2003-2009 онд бэлгийн мөлжлөгийн хэлбэрээр гэмт хэрэгт өртсөн 139 хүн Хүйсийн тэгш эрхийн төвөөс туслалцаа авчээ.

<sup>1</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг [www.upr-mongolia.mn](http://www.upr-mongolia.mn) вэб хуудаснаас үзнэ үү.

<sup>2</sup> Төрийн Бус Байгууллагуудын Хүний Эрхийн Зөвлөлд илгээсэн мэдээлэлд тулгуурлан бэлтгэсэн тул нэмж тоо баримт, жишээ, тохиолдол оруулах боломжгүй байсан болно.

Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилт сүл, гэрлэлт зуучлалын үйл ажиллагааг зохицуулах хуулийн заалт байхгүй, тусгай зөвшөөрлийн хуульд энэ үйлчилгээг ямар байгууллагад олгохыг заагаагүй.

- Гэрлэхэд зуучилна гэдэг нь конвенцийн заалтад харшилж байна.
- Зуучлагчаар дамжуулж гэрлэх байгаа хүмүүс нэг талын хатуу нөхцөлтэй гэрээнд гарын үсэг зурахад хүрдэг бөгөөд харийн нутагт очоод яаж ч эрх ашиг нь зөрчигдсөн бусдын эрхэнд орж, хохироход хүрдэг.
- Гэр бүл зуучлах үйл ажиллагаа явуулдаг байгууллага, иргэд хүссэн хэвлэл мэдээллийн хэрэгслээрээ дамжуулан зар гаргаж, ашиг олох боломжтой.

Гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах асуудлыг хуулиар зохицуулахдаа байгууллага зуучлахад бүрдүүлэх баримт бичгийн зассан ч "иргэн" зуучлахад ямар болзол шаардлага тавигдахыг тодорхой заагаагүй.

- Ямар ч иргэн энэ хуулийн хийдлийг ашиглан аливаа шалгуур үзүүлэлтгүйгээр бусдыг гадаадад ажилд зуучлах боломжтой нь хилийн чанадад боолчлолтой төстэй нөхцөлд хөдөлмөрийг нь мөлжих зорилготой хүн худалдаалах гэмт хэрэгт иргэд өртөх эрсдлийг нэмэгдүүлж байна.
- Гадаадад ажиллах хүч зуучлах зөвшөөрөлтэй компаниуд ихэвчлэн залуу эрэгтэйчүүдийг сонгодог тул гадаадад ажиллах сонирхолтой эмэгтэйчүүд өөр эрсдэлтэй зам хайхад хүрдэг.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 29, 105-р конвенцийн хэрэгжилт сүл, хэрэгжилтэд мониторинг хийсэн судалгаа, баримт хомс байна.

- Монголд дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай компани, аж ахуйн нэгж иргэдийг ажлын хүнд нөхцөлд, дөнгөж гол зогоо төдий хөлс олгон, хөдөлмөрийг нь мөлжиж ашиг олж байна.
- Хөдөлмөрийн мөлжлөгийн шинжтэй өөр хөргүүд ч гардаг.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт хангалтгүй. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй Нийэм хамгаалал хөдөлмөрийн яам идэвхитэй ажилладаггүй.

- Олон улсын хандивлагчдын санхүүжилт зогсвол энэ гэмт хэрэгтэй тэмцэх ажил зогсох хандлагатай байна.

2003-2007 онд гадаад хүнтэй гэрлэгсдийн тоо 54,1 хувиар өссөн. Тэдгээрийн 90-95 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд үүнээс 70 хувь нь Өмнөд Солонгосын иргэдтэй гэр бүл болжээ. Зуучлагчаар дамжуулан гэрлэх байгаа хүмүүс хуурамчаар гэрлэх, тодорхой шалтгаангүй салах үед 10,000 ам.доллар, гэрлэх өргөдлөө өгсний дараа татгалзвал 4,000 ам.доллар, Солонгост очсон хойноо зугтвал эцэг эх нь зуучлах товчоонд 4,5 сая төгрөг төлөх тухай хатуу нөхцөлтэй гэрээнд гарын үсэг зурахад хүрдэг. Захиалгат гэрлэлт хэлбэрээр хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн 47 иргэн Хүйсийн тэгш эрхийн төв, Хүний эрх хөгжил төв ТББ-аас туслалцаа авсан байна.

Иргэдийг Өмнөд Солонгос, Чех, Турк, Казахстан болон хөрш орнуудаар дамжуулан гуравдагч орнууд уруу худалдаалдаг. 2010 оны 1-р сарын байдлаар 92 хүн хөдөлмөрийн мөлжлөгөд өртөж, Хүйсийн тэгш эрхийн төвөөс туслалцаа авсан байна. Хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалсан нэг ч хэрэг шүүхээр шийдвэрлэгдээгүй.

Нийслэлд зарим цайны газар, тоосгоны үйлдвэр 30,0-50,0 мянган төгрөгийг хөдөлмөрийн хөлс хэмээн (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 108,0 мянга) олгож байна. Хятадын хөрөнгө оруулалттай нэг блокны үйлдвэрт ажилчдыг гаднаас нь цоожилж ажиллуулж байсан.

Олон улсын болон гадаадын хандивлагчид санхүүгийн голлох эх үүсвэрийг гаргаж байна. Төр засгаас явуулж буй үйл ажиллагаа нь зөвхөн хурал цуглаан хийх маягаар хязгаарлагдаж байна.

## МОНГОЛЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

- Хүн худалдаалах гэмт хэргийн суурь шалтгаан болсон ажилгүйдэл, ядуурлыг бууруулах чиглэлээр төрөөс оновчтой бодлого явуулах;
- Хөдөлмөрийн үнэлээмжид стандарт тогтоож, цалин хөлсийг нэмэгдүүлэх;
- Хүн худалдаалахын эсрэг бие даасан хууль боловсруулах, бусад холбогдолтой хуулийг шинэчлэн найруулж, хоорондын уялдаа холбоог сайжруулах;
- 2005 онд батлагдсан Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг шинэчилж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн асуудлыг тусгаж, хэрэгжүүлэх хөрөнгийг улсын төсвөөс хангалттай гаргах;

Монголчууд олноор зорчиж, амьдарч буй орнуудад байгаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт хүний эрхийн асуудал хариуцсан дипломат ажилтныг ажиллуулах;

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, гэрчид зориулсан хамгаалах байрыг (2) улсын төсвөөс 2011 оноос эхлэн бүрэн санхүүжүүлэх;
- Хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ хэрхэн хэрэгжүүлэх, гэмт хэрэгээс хэрхэн урьдчилан сэргийлэх зэрэг асуудлаар нөлөөлөл, сурталчилгааны ажлыг иргэдэд зориуулан зохион байгуулах болон
- Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудыг чадавхижуулах нь зүйтэй.